



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/101

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр Хулгана жилийн Цагаан сарын баярыг тохиолдуулан хөдөлмөрийн баатар, гавъяат цолтнууд, ахмад дайчид, 95-аас дээш настай ахмад настнууд, аймгийн Засаг даргын Тамгын газрын ахмадуудад хүндэтгэл үзүүлэх зардалд 3 880 000 төгрөгийн хавсралтаар баталж, дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 3 880 000 /Гурван сая найман зуун наян мянган/ төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээний 5. 23-д тусгагдсан "Ахмадаа ачлая" дэд хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ДҮГЭРЖАВ



02 00451  
D/Zax-A/101-Da

Аймгийн Засаг даргын 2020 оны  
02 дугаар сарын 17-ны өдрийн  
А/101 дүгээр захирамжийн хавсралт



АХМАДУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Үйл ажиллагааны зардал	Тоо ширхэг	Нэгж үнэ /төг/	Нийт /төг/
1	Цагаан сарын тавгийн боов	97 таваг	40000	3880000
	Нийт			3880000

-оОо-